



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 787

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1.4 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэлд барьж, ашиглалтад оруулсан, нийт 11,822,829,855.00 (арван нэгэн тэрбум найман зуун хорин хоёр сая найман зуун хорин есөн мянга найман зуун тавин таван) төгрөгийн үнэ бүхий 1 дүгээр хавсралтад заасан хөрөнгийг Нийслэлийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт барьж, ашиглалтад оруулсан, нийт 22,905,756,108.00 (хорин хоёр тэрбум есөн зуун таван сая долоон зуун тавин зургаан мянга нэг зуун найман) төгрөгийн үнэ бүхий 2 дугаар хавсралтад заасан хөрөнгийг Дорноговь, Дорнод, Завхан, Өвөрхангай, Төв, Ховд, Хэнтий, Сэлэнгэ болон Увс аймгийн өмчид тус тус бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга М.Баяраа болон тогтоолд заасан аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бурийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх;

3.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Нарангэрэл

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн ёмчийн бодлогого зохицуулалтын газрын
2021 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн
Ч.Энгэлаар тогтоолын 1 дүзэр хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ (БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХДАН, СПОРТЫН САЙДЫН БАГЦ (хуучин нэрээр)-ЭЭР
БАРЬСАН НИЙСЛЭЛИЙН ёМЧИД БУРТГЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт огноо	Дугаар	Ашиглагч байгууллага
1	Дүүргийн Спорт цогцолбор А, Б блок (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг)	1000 хүний суудалтай	11,822,829,855.00	2020.08.31	КД-54/2020 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүртийн Засаг даргын Тамгын газар
	Нийт дүн		11,822,829,855.00		

Төрийн ёмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 11 дугаар сарын 11-ны өдрийн
18 дугаар тогтолцоон 2 дугаар хавсралт

**УЛСЫН ТӨСВИЙН САНХУУЖИЛТ (БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХДАН, СПОРТЫН САЙДЫН БАГЦ (хуучин нарээр)-ЭЭР
БАРЬСАН ДОРНОГОВЬЯА, ДОРНОД, ЗАВХАН, ОВОРХАНГАЙ, ТӨВ, ХОВД, ХЭНТИЙ, СЭЛЭНГЭ БОЛОН УВС АЙМГИЙН
ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дунх (төгрөг)	Улсын комиссын акт		Ашиглагч байгууллага
				отноо	дугаар	
1	Спорт талбай /Дорноговь аймаг, Замын-Үүд сум/	500 хүний суудалтай	3,084,900,000.00	2018.12.24	УКД-05/2018	Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар
2	Спорт заалтын барилга /Дорноговь аймаг,Өргөн сум/		900,043,559.00	2019.11.29	УКД-83/2019	
3	Спорт цогцолборын барилга /Дорноговь аймаг,Хатанбулаг сум/	28.5 м*8.8 м-2ш 25.0 м*8.5 м-2ш	742,913,789.00	2020.12.04	УКД-88/2020	
4	Спорт заалтын барилга /Дорнод аймаг, Хэрлэн сум, 2 дугаар сургууль/		1,019,316,501.00	2019.03.12	003/2019	Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар
5	Спорт заалтын барилга /Дорнод аймаг, Чулуунхороот сум/		955,773,358.00	2020.12.22	127/2020	
6	Спорт цогцолборын барилга /Завхан аймаг, Улаастай сум/		7,210,176,200.00	2018.09.19	14/2018	Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар
7	Спорт заалтын барилга /Өвөрхангай аймаг,Өлзийт сум/		851,466,000.00	2019.10.17	БУ-27/2019	Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар
8	Спорт заалтын барилга,/Төв аймаг, Баянцогт сум/	36 м*20 м	639,510,020.00	2019.05.20	ББКД -06/19	Төв аймгийн Засаг даргын Тамгын газар
9	Спорт цогцолборын барилга, 450 суудал /Төв аймаг,Лун сум/	450 хүний суудалтай	1,859,935,843.00	2019.12.18	ББКД -85/19	
10	Спорт, заалтын барилга, 300 суудал /Ховд аймаг, Мөнххайрхан сум/ Спорт цогцолборын барилга /Хэнтий аймаг, Батширээт сум/	300 хүний суудалтай	2,662,935,379.00	2020.12.04	БУА/72/2020	Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар
11			825,566,739.00	2020.07.29	35/2020	Хэнтий аймгийн засаг даргын Тамгын газар
12	Спорт заалтын барилга /Сэлэнгэ аймаг, Алтанбулаг сум/		1,182,560,571.00	2020.07.06	БУ-45/2020	Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар
13	Спорт цогцолборын барилга /Увс аймаг.Өлтий сум/		970,658,149.00	2021.02.04	07/2021	Увс аймгийн Засаг даргын Тамгын газар
		Нийт дунх	22,905,756,108.00			